



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 569

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өргөө нөхсөн, ашиглалтын хугацаанд сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 24,111,614.00 /хорин дөрвөн сая нэг зуун арван нэгэн мянга зургаан зуун арван дөрвөн/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 4 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал И.Жанболатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан үндсэн хөрөнгийг сургалтын дадлагын хичээлд ашиглахаар байгууллагадаа үлдээж, эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн
569.. дугаар тогтоолын хавсралт



Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хурийтлагдсан элэгдэл /төгрөг/
1	ГАЗ 53, 19-47 БӨА, арал №1479750	1993/ 1995	6,874,200.00
2	Соната-2, 47-83 БӨА, арал №85094	1993/ 1993	8,140,500.00
3	ЗИЛ-130, 34-49 БӨА, арал №2423494	1985/ 2009	3,000,000.00
4	УАЗ-469, 30-05 БӨА, арал №407890	1999/ 1995	6,096,914.00
	Нийт дүн		24,111,614.00 <i>/хорин дөрвөн сая нэг зуун арван нэгэн мянга зургаан зуун арван дөрвөн/</i>